



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 397,189,667.56 (гурван зуун ерэн долоон сая нэг зуун наян есөн мянга зургаан зуун жаран долоон төгрөг тавин зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 16 ширхэг автомашин, 1 ширхэг автомашины чиргүүлийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лабораторийн захирал, Баянхонгор, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өмнөговь, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг оролцуулан, үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001024
4-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 2-дугаар сарын 26-ны /ний өдрийн
17-дугаар тогтоолын хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬА БАЙГУУЛЛАГЫН
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, төрөл	Улсын дугаар, сери	Арлын дугаар	Үйлдвэрлэс эн, Ашиглалта д орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Явсан км	Нэг бүрийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Дуудлага худалдаагаар худалдах доод үнэ (төгрөг)
	МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН ЛАБОРАТОРИ							
1	Суудлын автомашин Соната-6	78-26УБЧ	КМНЕТ41АР9А617561	2007/2009	1	101,488	1,000,000.00	3,500,000.00
	БАЯНХОНГОР АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР							
2	Ариутгалын Дук машин Потон форланд	59-68БНА	26965	2005/2005	1		20,757,000.00	5,000,000.00
	ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР							
3	Хагас ачааны автомашин /фермер/	06-21ГСА	330360C0493399	2012/2012	1		40,948,772.52	3,500,000.00
	ДУНДГОВЬ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР							
4	Суудлын автомашин Ниссан сани	53-07ДУА	FB15384597	2003/2010	1		7,200,000.00	3,500,000.00
5	Уаз чиргүүл			2003	1		271,350.00	300,000.00
6	Суудлын автомашин Ланд крузер 80	52-97ДУА	HDJ810052439	1995/2006	1		25,000,000.00	3,000,000.00

7	УАЗ 390945 фермер	71-91ДУА	330360С0487859	2012/2012	1		40,948,772.52	3,500,000.00
		ЗАВХАН АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР						
8	Ариутгал ДУК машин Потон Форланд	59-063АА	LVAV4JW655J026971	2005/2005	1		23,902,000.00	5,000,000.00
		ӨМНӨГОВЬ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР						
9	УАЗ 39094 фермер	68-78ӨМӨ	330360А0433376	2010/2011	1	50,200	19,990,000.00	3,500,000.00
		ХОВД АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР						
10	Суудлын автомашин Ланд крузер 80	12-24ХОУ	HDJ810060964	1995/2011	1	302,345	40,000,000.00	8,500,000.00
11	Хагас ачааны автомашин фермер Уаз 390942-018	55-04ХОА	330360А0432903	2010/2011	1	96,775	19,990,000.00	3,500,000.00
		ХӨВСГӨЛ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР						
12	Суудлын автомашин Форд эвэрист	66-68ХӨВ	MNCLS4D10BW314998	2011/2011	1		15,000,000.00	3,500,000.00
13	Уаз 3909 фургон	81-99ХӨВ	374100С0473736	2012/2012	1		20,920,000.00	3,500,000.00
14	Уаз 390945 фермер	88-41ХӨВ	330360С0488213	2012/2012	1		25,313,000.00	3,500,000.00
15	Дук автомашин Потон Форланд	71-63ХӨА	LVA4JW605J026960	2005/2005	1		40,948,772.52	5,000,000.00
		ХЭНТИЙ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАР						
16	Суудлын автомашин Ланд крузер 80	74-81ХЭА	FZJ8001216000	1995/2010	1	229807	25,000,000.00	3,000,000.00

17	Потон форланд ВJ5043 цистрен	83-22ХЭА	LVBV3JBV19E470610	2009/2009	1		30,000,000.00	5,000,000.00
	НИЙТ ДҮН				17		397,189,667.56	66,300,000.00
							(гурван зуун ерэн долоон сая нэг зуун наян есөн мянга зургаан зуун жаран долоон төгрөг тавин зургаан мөнгө)	(жаран зургаан сая гурван зуун мянга)